

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2025 оны 12 дугаар сарын 05-ны өдөр

Улаанбаатар хот

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
Зорилт 1. Хамрах хүрээний байгууллагуудыг тодорхойлж, улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөгдөж буй хууль тогтоомжийн хэрэгжилтэд дотоод аудит, санхүүгийн хяналт, шалгалт хийж илэрсэн зөрчил дутагдалд хариуцлага тооцох, хэрэгжилтийг хангуулах, мэргэжлийн зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх							
1.1	Төсвийн ерөнхийлөн захирагчийн хамрах хүрээний байгууллагуудын үйл ажиллагаанд дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт хийх	-	Дотоод аудит, санхүүгийн хяналт, шалгалтад хамрагдах байгууллагын тоо	23	38	2025 оны дотоод аудит, санхүүгийн хяналт, шалгалтын төлөвлөгөөний дагуу Хан-Уул зам засвар, арчлалт ОНӨААТҮГ, Эко хотын тээвэр ОНӨААТҮГ, Хан-Уул яармаг ОНӨААТҮГ, Тохижилт үйлчилгээний төв ОНӨААТҮГ, Эко ахмадын сувилал ОНӨААТҮГ, Хан-уул агро ОНӨААТҮГ, Нийтлэг үйлчилгээний алба ОНӨААТҮГ, Хан-Эко тээвэр ОНӨААТҮГ, 7-р сургууль, 15-р сургууль, 32-р сургууль, 41-р сургууль, 52-р сургууль, 59-р сургууль, 63-р сургууль, 75-р сургууль, 161-р сургууль, 163-р сургууль, 165-р сургууль, 12-р цэцэрлэг, 41-р цэцэрлэг, 145-р цэцэрлэг, 223-р цэцэрлэг, 312-р цэцэрлэгүүдэд дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт хийж, төлөвлөгөөт бус дээд газрын хүсэлтийн дагуу Хан-Уул дүүргийн Газар зохион байгуулалтын алба, Усан спорт сургалтын төвүүдэд хяналт, шалгалт хийж нийт 5,386,550.5 мянган төгрөгийн 201 зөрчил илрүүлж, үүнээс 4,203,537.0 мянган төгрөгийн 169 зөвлөмж, 1,172,297.2 мянган төгрөгийн 28 албан шаардлага, 10,716.3 мянган төгрөгийн 4 акт тус тус тогтоож, биелэлтийг хангуулан ажиллаж байна. Одоогийн байдлаар 18-р сургууль, 34-р сургууль, 115-р сургууль, 163-р сургууль, 35-р цэцэрлэг, 46-р цэцэрлэг, 144-р цэцэрлэг, 145-р цэцэрлэг, 209-р цэцэрлэг, 308-	100%

						р цэцэрлэг, 313-р цэцэрлэг, 322-р цэцэрлэг, 324-р цэцэрлэг, 325-р цэцэрлэг, 326-р цэцэрлэг, Нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажил зэрэгт дотоод аудитын удирдамжийн дагуу хяналт, шалгалт хийгдэж байна. Мөн дүүргийн Засаг даргын 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн "Хан-Уул дүүрэгт байрладаг бохир ус тээвэрлэх ажлыг гэрээгээр гүйцэтгүүлдэг сургууль, цэцэрлэгүүдэд хяналт шалгалт хийх тухай" 07 тоот удирдамжийн дагуу 11-н сургууль, 13-н цэцэрлэгт дотоод аудит, хяналт шалгалт хийж зөвлөмж, аргазүйгээр ханган ажиллалаа.	
1.2	Дээд байгууллага, дүүргийн Засаг дарга болон аудитын хорооны гишүүд, иргэд, байгууллагаас санал хүсэлт, өргөдөл гаргасан тухай бүр тусгайлсан аудитыг хийх	-	Санал хүсэлт, өргөдөл гаргасан тухай бүр тусгайлсан аудитыг хийсэн байдал хувиар	100%	100%	Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвд ирүүлсэн Хан-Уул дүүргийн Усан спорт сургалтын төв УТҮГ-ын үйл ажиллагаатай холбоотой 1 өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд хүлээн авч гомдлын дагуу санхүүгийн баримтад дотоод аудит, хяналт шалгалт хийж, шалгалтаар нийт 1,522.9 мянган төгрөгийн 9 зөрчил илрүүлж, 1,362.9 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 160.0 мянган төгрөгийн 2 акт тогтоож биелэлтийг хангуулан ажиллалаа.	100%
1.3	Тайлант онд дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтаар тогтоосон актын барагдуулалт	-	Актын төлбөр барагдуулалт хувиар	100%	100%	Тайлант хугацаанд дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтаар Хан-Уул дүүргийн Усан спорт сургалтын төв УТҮГ-ын үйл ажиллагаанд тогтоосон 160.0 мянган төгрөгийн 2 акт болон 59 дүгээр сургуульд тогтоогдсон 10,556.3 мянган төгрөгийн 2 актыг тус тус барагдуулсан болно.	100%
1.4	Дотоод аудитын хорооны хурлыг зохион байгуулах, шалгалтад хамрагдсан байгууллагуудын дүнг хэлэлцүүлэх	Батлагдсан төсвийн хүрээнд	Хурлын тоо	12	12	Тайлант хугацаанд дүүргийн Засаг дарга дотоод аудитын хорооны хурлыг 7 удаа хуралдуулсан бөгөөд тус хуралдаанд Дотоод аудитын 2025 оны аудитын төлөвлөгөө болон хяналт, шалгалтад хамрагдсан байгууллагуудын дүнгийн талаар тухай бүр хэлэлцүүлсэн болно.	60%
		-				Хан-Уул дүүргийн Засаг даргын 2025 оны 3 дугаар сарын 10-ны өдрийн 03 тоот "Хан-Уул	

1.5	Дүүргийн өрхийн эрүүл мэндийн төвүүдийн санхүүгийн үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг холбогдох хууль, журмын дагуу гүйцэтгэх		Хамрагдах байгууллагын тоо	-	4	дүүргийн Энхтитэм, Уясах, Амгалан-Өрх, Энхбуянт Манал өрхийн эрүүл мэндийн төвүүдийн 2023 он, 2024 он, 2025 оны 1, 2 дугаар сарын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх нэгдсэн удирдамж"-ийн дагуу дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт хийж нийт 1,357,109.0 мянган төгрөгийн 49 зөрчил илрүүлж, үүнээс 260,440.4 мянган төгрөгийн 19 зөвлөмж, 1,095,927.3 мянган төгрөгийн 29 албан шаардлага, 741.3 мянган төгрөгийн 1 акт тус тус тогтоосон.	100%
-----	---	--	----------------------------	---	---	--	------

Зорилт-2. Төсвийн Ерөнхийлөн захирагчийн хамрах хүрээний байгууллагуудын шилэн дансны үйл ажиллагаанд дотоод хяналт тавьж, хуулийн хэрэгжилтийг хангах

2.1	Шилэн дансны цахим системд хяналт тавьж, зөвлөмж арга зүйгээр хангах, мэдээлэл хоцроосон байгууллагуудын нэрсийг Засаг даргад танилцуулах	Хамрагдах байгууллагын тоо	23	92	Хамрагдах байгууллагын тоо	Дотоод аудитын алба нь Төсвийн тухай хуулийн 69.3, Шилэн дансны тухай хуулийн 3.1.1 болон 8.2 дахь заалт, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 9.1, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоол, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын 8.5 дахь заалтыг тус тус үндэслэн дүүргийн ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээний төсөвт болон төрийн чиг үүргийг гүйцэтгэгч 104 байгууллагад Шилэн дансны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавин сар бүр самбарт мэдээлэл байршуулан, дүүргийн Засаг даргад танилцуулж байна. Үүнд: 23 улсын сургууль, 42 улсын цэцэрлэг, 9 ОНӨААТҮГ, 8 дэргэдэх байгууллага, 22 өрхийн эмнэлэг байна. 2025 оны 10-р сарын байдлаар дүүргийн ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээний дээрх 104 байгууллагын мэдээллэвэл зохих 12154 мэдээллээс хугацаандаа оруулсан 11849 мэдээлэл, хугацаа хоцроосон 305 мэдээлэл, огт оруулаагүй мэдээлэл байхгүй	97,5%
-----	---	----------------------------	----	----	----------------------------	---	-------

						байна. Шилэн дансны цахим хуудасны мэдээлэл байршуулалт 97,5 хувьтай байна.	
2.2	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хянасан тухай мэдээг сар бүр самбарт байршуулж, тайлан мэдээг хугацаанд нь холбогдох байгууллагад хүргүүлэх	-	Самбарт байршуулсан мэдээллийн тоо	12	12	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээний төсөвт болон төрийн чиг үүргийг гүйцэтгэгч 104 байгууллагын мэдээллийг хянасан тухай мэдээг сар бүр мэдээллийн самбарт байршуулж мэдээллээ хоцроосон байгууллагуудад тухай бүр зөвлөгөө, мэдээлэл өгч ажиллаж байна.	100%
Зорилт-3. Төрийн захиргааны удирдлагын болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, чадвартай мэргэшсэн хүний нөөцийг бэлтгэх, нийгмийн баталгаагаар хангах							
3.1	Албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөө болон төлөвлөгөөний биелэлтийг холбогдох журамд заасан хугацаанд багтаан хянан баталгаажуулах	-	Арга хэмжээний хэрэгжилт, хувиар	96%	96%	Албаны дарга албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг холбогдох журмын дагуу баталсан бөгөөд албан хаагчдын хагас, бүтэн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг үнэлэх журмын дагуу үнэлж, дүгнэн, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох” тухай журмыг үндэслэн төрийн албан хаагчдад ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнгийн урамшууллыг олгосон.	100%
3.2	Байгууллагын дотоод үйл ажиллагааг зохицуулсан дүрэм, журмыг шинэчлэн боловсруулж, баталгаажуулах	-	Арга хэмжээний хэрэгжилт, хувиар	100%	100%	Албаны дотоод журмыг шинэчлэн боловсруулж албаны дарга болон бүх албан хаагчдын саналыг тусган нэгтгэж албаны даргын 2025 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн А/07 дугаар тушаалаар шинэчлэн баталсан.	100%
3.3	Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, хууль тогтоомж, ЗГҮАХ, ЗДҮАХ болон тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж албан тушаалтанд хүргэх	-	Мэдээ тайлан, биелэлт, хугацаандаа, чанартай тайлагнасан байдал	100%	100%	Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 2025-2028 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулсан бөгөөд төлөвлөлтийг байгууллага болон албан хаагчдын 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, байгууллагын үйл ажиллагааны бусад төлөвлөгөөнүүдийг уялдуулан боловсруулж дүүргийн Засаг даргаар батлуулсан. Мөн тогтоол шийдвэрийн	100%

						биелэлтийг улирал бүр хугацаанд нь тайлагнаж, хагас, бүтэн жилийн тайланг ЗДТГ-т хүргүүлээд байна.	
3.4	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журмын хэрэгжилтийг хангаж ажиллах	-	Арга хэмжээний хэрэгжилт, хувиар	100%	100%	Тус байгууллагын бүх албан хаагчид архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журмын хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Мөн дотоод аудит, хяналт шалгалтад хамрагдаж буй байгууллагуудын албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд тус хуулийн хэрэгжилтэд зөвлөмж, арга зүйгээр ханган ажиллаж байна. 2025 оны 10 дугаар сарын 14-ний өдөр Төрийн байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгт хуваарийн дагуу 3 үндсэн үзүүлэлт, 87 шалгуур үзүүлэлтийн дагуу 2020-2024 оны байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаа болон байгууллагын ажлын зохион байгуулалтыг тус тус дүгнүүлсэн.	100%
3.5	Албан хэрэг хөтлөлтийн E-doc систем ашиглалтыг сайжруулах, зөрчилгүй ажиллах, ирсэн албан бичиг, өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэх, дундаж хугацаа багасгах	-	Хуулийн хэрэгжилт, хувиар	100%	100%	Тайлант хугацаанд албан хэрэг хөтлөлтийн E-doc системээр байгууллагын хэмжээнд 133 албан бичиг ирснээс хариутай 26, хариугүй 107 албан бичгийг албан хаагчид хуулийн хугацаанд нь бүрэн шийдвэрлэж ажилласан. Шийдвэрлэлтийн дундаж хугацаа 95.4 хувьтай шийдвэрлэлтийн хоног 3.09 байна. Явсан бичиг 44 албан бичгийг холбогдох байгууллагад хүргүүлж шийдвэрлэлтийн дундаж 100 хувьтай хангагдсан байна.	97,7%
3.6	Төрийн албан хэрэг хөтлөлтийг хос бичгээр хөтлөх, албан хаагчдыг чадавхжуулах	-	Арга хэмжээний хэрэгжилт, хувиар	100%	100%	Байгууллагын бүх албан бичиг, тушаал шийдвэрүүдийг хос бичгээр хөтөлж байна. Мөн албаны бүх албан хаагчид Монгол бичгийн сургалтад хамрагдаж анхан, дунд шатны түвшнийг эзэмшиж гэрчилгээ авсан.	100%
3.7	Өргөдөл гомдлын шийдвэрлэлт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг хугацаанд нь	-	Өргөдөл гомдлын шийдвэрлэлт, хувиар	-	100%	Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвд ирүүлсэн Хан-Уул дүүргийн Усан спорт сургалтын төв УТҮГ-ын үйл ажиллагаатай холбоотой 2, Зам засвар арчлалт ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаатай холбоотой 1 гомдлыг хуулийн хугацаанд хүлээн авч гомдлын дагуу	100%

	гаргаж, холбогдох нэгж албан тушаалтанд хүргэх					хяналт, шалгалт хийж, холбогдох тайлан, мэдээг хуулийн хугацаанд хүргүүлж ажиллалаа.	
3.8	Байгууллагын хүний нөөцийн өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулах, хэрэгжилтийг хангуулах	Батлагдсан төсвийн хүрээнд	Арга хэмжээний хэрэгжилт, хувиар	100%	100%	Дотоод аудитын албаны 8 албан хаагчийн цалингийн сүлжээ, хоол унааны нэмэгдэл, зэрэг, дэв болон бусад нэмэгдлүүдийг ХНУМТ цахим системд шинэчлэн бүртгэлээ. Мөн шинээр ажилд орсон болон ажлаас чөлөөлөгдсөн албан хаагчдын холбогдох тушаал шийдвэрийг үндэслэн өөрчлөлтийг тухай бүр хийж байна.	100%
3.9	Төрийн албан хаагчийн сургалт, албан хаагчийн нийгмийн баталгааг хангах төлөвлөгөөг батлуулж, албан хаагчдыг хамруулах	Батлагдсан төсвийн хүрээнд	Арга хэмжээний хэрэгжилт, хувиар	100%	100%	Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд 2025 оны төлөвлөгөөг албаны дарга баталж хэрэгжилтийг ханган ажиллалаа. Тайлант хугацаанд албан хаагчдыг 9 төрлийн сургалтад хамруулахаар төлөвлөгөөг баталсан бөгөөд албан хаагчид бүрэн хамрагдаж 100 хувийн биелэлттэй байна. - Худалдан авах ажиллагааны АЗ сургалтад Б.Туул, Ү.Шинэтөр, Ц.Түвшинхүү, С.Золзаяа нар - Дотоод аудитын албаны албан хаагчдын санаачилгаар “Эрүүл зөв хоололт ба чанартай нойр” сургалтад бүх албан хаагчид - Төрийн албан хаагчийн ёс зүйн сургалтад бүх албан хаагчид “Монгол бичгийн дунд шатны” сургалтад С.Золзаяа, М.Өлзийхишиг, Б.Мөнхзаяа, Э.Цэцэгээ, Ү.Шинэтөр, Ц.Түвшинхүү нар - Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан ХАСХОМ нөхөн бүрдүүлэх тухай цахим сургалтад байгууллагын 7 албан хаагч - Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн санаачилгаар “Бүсчилсэн	100%

						хөгжил-Төрийн албаны манлайлал” сэдэвт зөвлөгөөнд Б.Туул, Б.Мөнхзаяа ▪ Жендэрийн Үндэсний хорооноос зохион байгуулсан Удирдах албан тушаалтанд зориулсан жендэрийн цахим сургалтад 7 албан хаагч ▪ Баянгол дүүргийн Дотоод аудитын албанаас санаачлан Сангийн яамтай хамтран 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдөр зохион байгуулсан үзүүлэх сургалтад 7 албан хаагч ▪ Татварын мэргэшсэн зөвлөхийн сургалтад Б.Мөнхзаяа, Э.Цэцэгээ, Ү.Шинэтөр, Ц.Түвшинхүү нар ▪ Нийслэлийн өмчийн харилцааны газраас зохион байгуулсан сургалтад М.Өлзийхишиг, Б.Нямсүрэн ▪ СТСХ-ээс 2025 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр зохион байгуулсан Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Татварын хуулийн шинэчлэлтийн талаарх сургалтад Б.Нямсүрэн ▪ Архивын ахисан шатны сургалтад М.Өлзийхишиг ▪ MS Power point мастер сургалтад М.Өлзийхишиг ▪ Монгол Улсын Сангийн яам, Азийн Хөгжлийн Банк (АХБ)-тай хамтран 2025 оны 11 дүгээр сарын 13, 14-ний өдрүүдэд зохион байгуулсан "Улсын салбарын дотоод аудитуудыг чадавхжуулах, олон улсын туршлага солилцох зөвлөгөөнд албан хаагчид цахимаар бүрэн хамрагдсан. Албан хаагчдын ажлын идэвх санаачлагыг дээшлүүлэх, тогтвор суурьшилтай ажиллах сонирхлыг нэмэгдүүлэх зорилгоор байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын	
--	--	--	--	--	--	--	--

						дагуу 1 албан хаагчид 2,430.0 мянган төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж, 4 албан хаагчдад орон сууц худалдаж авахад дэмжлэг үзүүлж 30,000.0 мянган төгрөг нийт 32,430.0 мянган төгрөгийн буцалтгүй тусламжийг олгосон.	
3.10	Албан хаагчдын эрүүл мэндийг дэмжих, эрүүл амьдралын хэв маяг, нийтийн биеийн тамирын үйл ажиллагааг хэвшүүлэх	Батлагдсан төсвийн хүрээнд	Арга хэмжээний тоо	1	1	Албан хаагчдын эрүүл мэндийг дэмжих талаар албан хаагч өөрөө болон гэр бүлийн хүн эмнэлэгт хэвтэх болон үзүүлэхэд цалинтай чөлөө олгож байна. Мөн албан хаагчдыг жилд нэг удаа эрүүл мэндийн үзлэгт хамруулах үйл ажиллагааны хүрээнд 2025 оны 4 дүгээр улиралд эрүүл мэндийн үзлэгт бүх албан хаагчдыг хамруулаад байна.	100%
3.11	Авилгын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөрт заасан чиг үүргийг хэрэгжүүлэх, холбогдох сургалтад хамрагдах	-	Хуулийн хэрэгжилт, хувиар	100%	100%	АТГ-ын даргын тушаалаар батлагдсан хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах албан тушаалтны жагсаалтын дагуу 8 албан хаагчийн 2024 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг 2 дугаар сарын 15-ны өдрийн дотор хуулийн хугацаанд нь хүлээн авч дүүргийн ЗДТГ-н ЭБАТ-д хүргүүллээ. Тайлант хугацаанд хяналт шалгалтад хамрагдах байгууллагуудад дотоод аудит хийхээс өмнө ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэлийг аудитуудаас тухай бүрт гаргуулж Авлигатай тэмцэх газрын https://meduuleg.iaac.mn/ сайтад тайлагнаж ажиллалаа. Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан ХАСХОМ нөхөн бүрдүүлэх тухай сургалтад байгууллагын албан хаагчид цахимаар бүрэн хамрагдсан.	100%
						Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т "Төрийн ба төсөвт байгууллагын нийт ажилтны дунд аль	

3.12	Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль"- ийн хэрэгжилтийг хангах ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хагас, бүтэн жилээр тайлагнах	-	Хуулийн хэрэгжилт, хувиар	100%	100%	нэг хүйсийн төлөөлөл илт давамгайлсан тохиолдолд хүйсийн 40:60 гэсэн харьцаа бүхий тэнцвэрт байдлыг хангах" гэж заасны дагуу тус албанд эмэгтэй 60, эрэгтэй 40 гэсэн хүйсийн харьцаатайгаар хүйсийн тэнцвэртэй байдлыг ханган ажиллаж байна. Тус албаны дотоод журмын "4 дүгээр зүйлийн 4.4.7 ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд жендерийн ялгаварлан гадуурхалтаас ангид байлгах, дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамтыг хориглох талаар Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.5, 11.6, Хөдөлмөрийн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан үүргийг хүлээнэ" гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаж байна. Жендерийн Үндэсний хорооноос зохион байгуулсан Удирдах албан тушаалтанд зориулсан жендерийн цахим сургалтад хамрагдаж 7 албан хаагч хамрагдаж гэрчилгээ авсан.	100%
3.13	Байгууллагын эцэг эхийн зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулах, хэрэгжилтэд хяналт тавих	-	Арга хэмжээний хэрэгжилт, хувиар	100%	100%	Байгууллагын эцэг эхийн зөвлөлийн 2025 оны төлөвлөгөөний дагуу байгууллагын эцэг эхийн зөвлөл нь албан хаагчдын гэр бүл, хүүхдэд чиглэсэн дараах үйл ажиллагааг зохион байгуулж ажиллалаа. Үүнд: ➢ Эцэг, эхийн "SCHOOL POLICE" эргүүлийн үйл ажиллагаанд 2 албан хаагч сургуулийн орчинд үүрэг гүйцэтгэн ажиллахад цалинтай чөлөө олгон дэмжлэг үзүүллээ. ➢ Ахуйн хүрээнд гарч байгаа эрсдэлийг бууруулах талаар эцэг, эхчүүдэд зориулан санамж, сэрэмжлүүлгийг хэвлэн, түгээсэн. ➢ Хүүхдэд зөв зохистой хоол хүнс хэрэглүүлэх, чанарын баталгаагүй, хориглосон хүнсний бүтээгдэхүүн, чихэрлэг хүнсээр хангахгүй байх	100%

						талаар цахим сургалтыг зохион байгуулсан. ➤ Цахим орчин дахь хүүхдийн мэдээллийн аюулгүй байдлын талаарх мэдээллийг байгууллагын албан хаагчдад танилцууллаа. ➤ Ерөнхий боловсролын сургуулиас зохион байгуулагдсан эцэг, эхийн өдөрлөгт 1 албан хаагчийг оролцуулсан. ➤ Хүүхдийн баяраар албан хаагчдын хүүхэд бүрт гарын бэлэг өгч баярлууллаа.	
3.14	Ёс зүйн дэд хорооны төлөвлөгөө, тайланг батлуулж хугацаанд нь дээд байгууллагад тайлагнан ажиллах	-	Арга хэмжээний хэрэгжилт, хувиар	100%	100%	Тайлант хугацаанд байгууллагын дэргэдэх ёс зүйн дэд хороог 3 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр шинээр байгуулж 2025 оны төлөвлөгөөг батлуулан төлөвлөгөөний дагуу ажиллаж байна. Ёс зүйн дэд хороо нь тус онд нийт 6 удаа хуралдаж, 5 тогтоол гаргаж, тайлан мэдээг хугацаанд нь https://hrm.csc.gov.mn/ сайтад тайлагнан ажиллалаа. Мөн Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн хүрээнд Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын Ёс зүйн дэд хорооноос “Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх сарын аян”-ыг зохион байгуулж аяны туг аялуулсан. Дотоод аудитын алба нь ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх аяны тугийг 2025 оны 4 дүгээр сарын 29-ний өдрөөс 5 дугаар сарын 06-ны өдрийг хүртэлх хугацаанд аялуулахдаа нийт 7 ажил төлөвлөн зохион байгуулж биелэлтийг хугацаанд нь Засаг даргын Тамгын газрын Ёс зүйн дэд хороонд тайлагнаж ажилласан.	100%
						Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн дагуу хөдөлмөрийн аюулгүй	

3.15	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний тухай хуулийн хэрэгжилтийг ханган, тайлагнан ажиллах	-	Хуулийн хэрэгжилт, хувиар	100%	100%	байдал хариуцсан ажилтан томилсон бөгөөд тус онд хийх ажлын төлөвлөгөөг баталж, төлөвлөгөөний дагуу албаны даргад тайлагнаж ажиллалаа. Тайлант хугацаанд албан хаагчдын ажиллах өрөөний хүрэлцээ муугаас албан хаагчдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйд тулгамдсан асуудлыг шийдвэрлэх үүднээс дүүргийн Засаг даргад нөхцөл байдлыг танилцуулж, шийдвэрлүүлсэн бөгөөд албан хаагчдын суух 1 өрөө нэмэгдсэн. MNS 5027:2001 стандартын дагуу албаны өрөө тасалгааны тоног, төхөөрөмж, тавилгын байрлалыг өөрчлөх зохион байгуулалтуудыг хийж албан хаагчдад галын анхан шатны багаж хэрэгслийг ашиглах, гал унтраагуурын төхөөрөмжийг ажиллуулах, ажлын байрны аюулгүй байдлын талаарх сургалт, заавар зөвлөгөөг тухай бүрт өгч ажилласан. Мөн ажил гүйцэтгэх явцад албан хаагчдын биед ямар нэг зовуурь илрэх, эрүүл мэндэд таагүй нөхцөл үүсвэл анхан шатны түргэн тусламж болох эмийн санг албаны өрөөнд байршууллаа. Хөгжлийн бэрхшээлтэй хүний тухай хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс тус албанд ажиллаж буй 2 албан хаагчид сурч боловсрох, хөдөлмөрлөх, нийгэмших зэрэг харилцаанд оролцох хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг саадгүй, хүртээмжтэй хангах орчин, нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна.	100%
3.16	Удирдлагаас цаг үеийн асуудлаар болон шуурхай зөвлөгөөн дээр өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх, албан хаагчдаа мэдээллээр хангах	Батлагдсан төсвийн хүрээнд	Арга хэмжээний хэрэгжилт, хувиар	100%	100%	Нийслэл, дүүргийн удирдах ажилтны шуурхай үүрэг даалгавараас өгөгдсөн 8 удаагийн үүрэг даалгаврын биелэлтийг гаргаж тайланг ЗДТГ-т хүргүүллээ.	100%
						-Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/33 дугаар захирамж, Хан-Уул дүүргийн Засаг даргын 2025 оны А/20 дугаар захирамжийн	

3.17	Нийслэл дүүрэг бусад холбогдох газруудаас зохион байгуулсан бусад ажилд идэвхтэй оролцох	Батлагдсан төсвийн хүрээнд	Арга хэмжээний хэрэгжилт, хувиар	-	Тухай бүр	дагуу 2025 оны 01 дүгээр сарын 18, 19-ний өдрүүдэд дүүргийн 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12, 13, 14, 16, 21, 22, 23 дугаар хороодод агаар бохирдуулагч эх үүсвэрийн судалгаа гаргах, хяналт шалгалтад тус албаны албан хаагчид бүгд идэвхитэй оролцсон. Мөн Улаанбаатар марафон-2025 арга хэмжээ, бүх нийтийн гамшгаас хамгаалах бэлэн байдлын дуут дохиогоор ажиллах үйл ажиллагаа, Монгол улсын ерөнхийлөгчийн нэрэмжит “Бие бялдарын хөгжил чийрэгжилтийн түвшин тогтоох сорил”, Хан-Уул дүүргийн 60 жилийн ойн баярын хурал, бөхийн барилдаан, Хан-Уул дүүргийн Засаг даргын нэрэмжит спортын 5 төрөлт тэмцээн зэрэг арга хэмжээнүүдэд тухай бүр баг, хамт олноор амжилттай оролцон “Дартс”-ны ганцаарчилсан төрөлд 3-р байр, Корнхалл-ын багийн төрөлд 3-р байр тус тус эзэлж хүрэл медалийн эзэд болсон. Тайлант хугацаанд Нийслэл дүүрэг болон бусад холбогдох газруудаас зохион байгуулсан бүх арга хэмжээнд байгууллага, хамт олноор идэвхтэй оролцсон болно.	100%
3.18	“Тэр бум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд мод, бут тарьж ургуулах, арчлах	-	Шинээр тарьж ургуулах модны тоо	10	10	Тэрбум мод тарих үндэсний өдрийн хүрээнд 2025 оны 5 дугаар сарын 10-ны өдөр Хан-Уул дүүргийн 13 дугаар хороо, Агро паркийн талбайд нийт албан хаагчдын тоогоор 8 мод, 2025 оны 10 дугаар сарын 11-ний өдөр Хан-Уул дүүргийн 14 дүгээр хороонд байрлах Айцын амны ойжуулалтын талбайд 40 мод тус тус тарьсан.	100%
			Арчилж ургуулах модны тоо	40	40	Дотоод аудитын албаны албан хаагчдын санаачилгаар дүүргийн иргэдэд үйлчлэх байрны баруун талбайд тарьсан 40 гаруй модны усалгаа, арчилгаа, нөхөн сэргээлтийг тогтмол хийж байна.	
						Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчаас 2025 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн шуурхай	

3.19	Бүх нийтийн их цэвэрлэгээнд тухай бүр оролцох	-	Их цэвэрлэгээнд оролцсон байдал, цэвэрлэгээ зохион байгуулсан тоо	12	Тухай бүр	зөвлөгөөнөөр өгсөн үүрэг даалгаврын дагуу дүүргийн нутаг дэвсгэрт хамаарах Туул гол, Дунд голын эрэг дагуу үүссэн хог хаягдлыг цэвэрлэх, ариутгах нэгдсэн их цэвэрлэгээ 2025 оны 7 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулагдаж тус албаны 4 албан хаагч хамрагдсан. Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн баталсан “Бүх нийтийн их цэвэрлэгээ”-ний хуваарийн дагуу 3 дугаар сарын 29-ний өдөр тус албаны 8 албан хаагч дүүргийн гадна талбайн хог хаягдлыг цэвэрлэсэн. Хан-Уул дүүргийн Засаг даргын захирамжийн дагуу: • “Эхний ээлжийн бүх нийтийн их цэвэрлэгээ” 2025 оны 1 дүгээр сарын 31-ний өдөр зохион байгуулагдаж тус албаны 7 албан хаагч дүүргийн гаднах явган хүний замын цас, мөсийг цэвэрлэсэн. • 2025 оны 2 дугаар сарын 22-ны өдөр зохион байгуулагдсан арга хэмжээнд тус албаны 8 албан хаагч хамрагдаж дүүргийн баруун талын талбайн хог, цас, мөсийг цэвэрлэсэн. • “Хаврын бүх нийтийн их цэвэрлэгээ” 2025 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр зохион байгуулагдаж тус албаны 7 албан хаагч Туул голын ай савын эрэг орчмын хог хаягдлыг цэвэрлэсэн. • “Хоггүй Хан-Уул” аяны хүрээнд “Намрын бүх нийтийн их цэвэрлэгээ” 2025 оны 9 дүгээр сарын 27-ны өдөр зохион байгуулагдаж 8 албан хаагч дүүргийн гадна талбайн хог хаягдал, шарилжийг цэвэрлэж тухай бүр идэвхтэй оролцож ажилласан.	100%
	Чиг үүргийн дагуу хэрэгжүүлж буй үйл ажиллагааны мэдээ,					Албаны www.khanuul-audit.mn цахим хуудасны үйл ажиллагааны ил тод байдлын цэсэнд 2025	

3.20	мэдээллээ тухай бүр дүүргийн албан ёсны /www.khanuul.mn/ веб хуудаст байршуулж, иргэдийг үнэн зөв, шуурхай мэдээллээр ханган, цахим мэдээллийн сувгаар уялдаа холбоотой, нягт хамтран ажиллах	-	Цахим хаягаар мэдээлэгдсэн мэдээллийн тоо	15	15	оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, хяналт шалгалтын календарьчилсан төлөвлөгөө, Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх албан хаагчдын нийгмийн баталгааг хангах 2025 оны төлөвлөгөө, нийслэл дүүргээс зохион байгуулсан 3 удаагийн ажил арга хэмжээг тус тус байршууллаа. Мөн “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль”-ийн 8.2, 8.3, 8.4 дүгээр зүйлд заасан мэдээллийг тухай бүр шинэчилсэн байршуулан ажиллалаа.	100%
Зорилт-4. Албаны санхүүгийн удирдлага, төлөвлөлт, гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулж, үр дүнг тайлагнах үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулах, олон нийтэд ил тод нээлттэй мэдээлэх							
4.1	Байгууллагын аж ахуйн өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулах, албан хаагчдыг шаардлагатай хөрөнгө материалаар хангаж, хөрөнгийн хөдөлгөөн, хадгалалт хамгаалалтад бүртгэлээр хяналт тавих	Батлагдсан төсвийн хүрээнд	Арга хэмжээний хэрэгжилт, хувиар	100%	100%	Албаны даргын тушаалыг үндэслэн хуулийн хугацаанд эд хөрөнгийн тооллогыг хийсэн бөгөөд 2025 оны жилийн эцсийн байдлаар 112 нэр төрлийн 96,568.1 мянган төгрөгийн дараах хөрөнгийг тоолж, тооцоо бодсон актаар баталгаажуулсан. Машин тоног төхөөрөмж 39 нэр төрлийн 69,307.2 мянган төгрөг, тавилга эд хогшил 67 нэр төрлийн 25,072.4 мянган төгрөг, программ хангамж 2 нэр төрлийн 1,870.0 мянган төгрөг, аж ахуйн материал 4 нэр төрлийн 318.5 мянган төгрөг байна. Өмч хамгаалах байнгын зөвлөл хийсэн ажлын төлөвлөгөө, тайланг албаны даргад танилцуулж ажиллалаа. Тайлант хугацаанд хөрөнгө актлах устгах талаар шийдвэр гараагүй болно.	100%
4.2	Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зориулалтын дагуу зарцуулах, авлага өр, төлбөр үүсгэхгүй байх, санхүүгийн сахилга батыг хэрэгжүүлэх санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайланг	Батлагдсан төсвийн хүрээнд	Арга хэмжээний хэрэгжилт, хувиар	100%	100%	2025 онд 667,825.8 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 430,442.9 мянган төгрөг зарцуулж 237,382.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй, өр, авлага үүсгэхгүй ажиллалаа.	100%

	үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах						
4.3	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, санхүүгийн ил тод байдлыг хангаж ажиллах	-	Хугацаандаа мэдээлсэн мэдээллийн тоо	171	171	2025 оны жилийн эцсийн байдлаар мэдээлбэл зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 145 мэдээлэл, хугацаа хоцроосон 4 мэдээлэл, огт оруулаагүй мэдээлэл байхгүй болно. Шилэн дансны цахим хуудасны мэдээлэл байршуулалт 97,3 хувьтай байна.	97,3%

Төлөвлөгөөг хянасан:
ЗАСАГ ДАРГА



Төсвийн Ерөнхийлөн захирагч
Б.ЦЭРЭН

(огноо)

Төлөвлөгөө тайлагнасан:
ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ДОТООД АУДИТЫН
АЛБАНЫ ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Тэмдэг



Төсвийн Шууд захирагч
Б.ТУУЛ

(огноо)